

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2018.06.27

Мандалговь

Тус салбар зөвлөл нь Төрийн албаны шинэтгэлийн стратегүүд болон Засгийн газрын шинэчлэлийн бодлогыг орон нутагт өргөн далайцтай хэрэгжүүлж үр дүнд хүргэхийг зорилго болгон энэ ажлын хүрээнд үндсэн ажлаа төлөвлөж, тодорхой удирдамж, чиглэл, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг улирал тутам дүгнэж, эрчимжүүлж ажиллалаа.

Салбар зөвлөлөөс 2018 оны эхний хагас жилд зохион байгуулж хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн ажил дүгнэх үзүүлэлт”-ийн дагуу танилцуулж байна.

Нэг. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажил үр дүн

Тус Салбар зөвлөлөөс төрийн албаны хууль тогтоомж, стандартуудын хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, шинэ арга туршлагыг нэвтрүүлэх, төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, тэднийг чадваржуулах, ажлын бүтээмж, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд ахиц дэвшил гаргах зорилт дэвшүүлэн тодорхой ажлууд зохион байгуулж ажилласан.

Засгийн газрын 2007 оны 186 дугаар тогтоолоор баталсан төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх улсын төлөвлөгөөнд үндэслэн, аймгийн салбар зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна.

Хоёр. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн.

Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 91 дүгээр албан тоотоор ирүүлсэн загварын дагуу аймгийн салбар зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөг стратегийн 5 үндсэн зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэх 40 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур тоо чанар, хугацаагаар тодорхойлон төлөвлөж, салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулан хэрэгжүүлж, улирал тутам үр дүнг тооцож ажилласан. Төлөвгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 100%-28, 70%-9, ХБ-3, хэрэгжилтийн хувь 92,7 байна.

/Төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг www.Dundgovi.mn сайтын Төрийн албаны салбар зөвлөл /ТАСЗ/ талбарын “Ил тод байдал” хэсгийн “Ажлын тайлан”-д байршуулан сурталчилсан болно./

Гурав. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал

2018 оны эхний хагас жилд Салбар зөвлөлийн хурлыг 8 удаа хийсэн. Зөвлөлийн хурлаар зарим албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгох, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын комисс байгуулах, сонгон шалгаруулалтын дүнгийн тухай, дүгнэлт гаргах тухай, албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай, зарим иргэдийн өргөдөл гомдлын тухай, төрийн албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулж явуулах, шалгалтын дүнгийн тухай, хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулах, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаа”-нд

хийсэн нийцлийн аудитын дүнгийн тухай зэрэг цаг үеийн тулгамдсан 29 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 34 тогтоол гаргасан.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг 2018 оны 1 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, Төрийн албаны салбар зөвлөлөөс 2017 онд 16 хурал хуралдуулж, 71 асуудал шийдвэрлэснээс 100%-66, 90%-5 хэрэгжилт 99,3% байна гэж дүгнэлээ.

2018 оны эхний хагас жилд 8 хуралдаанаар 29 асуудал шийдвэрлэснээс 100% хэрэгжилттэй 24, 70 хувь -5, хэрэгжилтийн хувь 94,83.%-тай байна.

/Хуралдааны шийдвэрийн биелэлтийг www.Dundgovi.mn сайтын Төрийн албаны салбар зөвлөл /ТАСЗ/ талбарын “Тогтоол, шийдвэр” хэсгийн Хуралдааны шийдвэрт байршуулан сурталчилсан болно./

Хуралдааны тэмдэглэлийг хуралдаанаас хойш 3 өдрийн дотор албажуулах талаар Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажлын төлөвлөгөөнд тусган бүрэн хөтөлж албажуулсан.

Дөрөв. Орон нутаг салбарын хэмжээнд хууль, журам заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхт хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгсөн байдал, үр дүн

Төрийн албаны стандарт, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалган туслах ажлын байнгын удирдамжийн дагуу салбар зөвлөлийн гишүүд хариуцсан сум, байгууллага, хэлтэс, агентлагууддаа төрийн албаны хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх ажлыг явуулж, хууль, тогтоомж, журам зааврын зөрчлийг арилгуулах, гарсан шийдвэрийг хангуулах арга хэмжээ тогтмол авч ирлээ.

Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Гурвансайхан сумдад Төрийн хууль тогтоомж, төрийн албаны стандартын хэрэгжилтэд зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, зөвлөмж чиглэл өгсөн.

Дэрэн сумын ЗДТГазраас сумынхаа Цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд Баянжаргалан сумын ЗДТГазраас ЕБС, цэцэрлэг, Соёлын төв, ЭМТ-д төрийн албаны стандартын хэрэгжилтэнд удирдамжийн дагуу шалган зааварлаж, хугацаатай үүрэг даавгавар, зөвлөгөө өгч эрчимжүүлж ажилласан.

Хулд сумын ЗДТГазраас ЗДТГ, Цэцэрлэг, Хүн эмнэлэг, ЕБС-ийн, Дэлгэрхангай сумын ЗДТГазраас Соёлын төв, ЕБС-ийн стандартын хэрэгжилтийн тайлан сонсголыг, Говь-Угтаал сумын ЗДТГазраас ЕБС-ийн дотоод хяналт шалгалтын дүнг, Соёлын төвийн Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтын тайлан мэдээг ЗД-ын дэргэдэх зөвлөлийн хурал болон ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, зөвлөмж, заавар, үүрэг чиглэл өгсөн байна.

Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод анализ, дүгнэлт хийж, албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Цагаандэлгэр, Хулд, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Эрдэнэдалай сум, Санхүүгийн хяналт, аудитын алба, Хөдөлмөр халамж үйлчилгээний алба, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, соёл, урлагийн газар зэрэг байгууллагууд “Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт”-ыг шинэчлэх ажлын хэсэг томилон, ажлын байран дээрх зураг авалтыг хийж, давхар ажил эрхлэх боломжтой ажлын байр, албан тушаалыг судалж, зарим орон тоог нэгтгэн, нэмэгдүүлж бүтэц орон тоог өөрчлөн батлуулж, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтоо шинэчлэн ачааллыг тэнцвэржүүлсэн байна.

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөө”, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХ-ын захиалгаар Төрийн аудитын

тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн 2015, 2016, 2017 оны үйл ажиллагааны баримт материал, хурлын тэмдэглэл, тогтоол, шийдвэрүүд, нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалга, холбогдох бусад эрх зүйн актуудад тулгуурлан нийцлийн аудит хийлээ.

/Аудитын тайланг www.audit.mn Үндэсний аудитын газрын цахим сайтаас үзэж болно./

Төрийн захиргааны албан тушаалд байгаа зөрчилтэй томилгоог арилгах хугацаатай үүрэг даалгаврыг төрийн бүх байгууллагуудад өгч, нийцлийн аудитаар илэрсэн төрийн захиргааны албан тушаалд зөрчилтэй томилгоог арилгаагүй, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч болон хууль бус томилгоог шинээр хийсэн 5 байгууллагын удирдах ажилтанд хариуцлага тооцуулах албан бичгийг дээд шатны удирдлагад нь, 2 байгууллагын удирдлагад зөрчил арилгах албан бичиг хүргүүлжээ.

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүний нөөцийн бодлого, төрийн албаны стандартын хэрэгжилтийн тайлан сонсголыг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн, зөвлөмж чиглэл өгч ажилласан.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг нийт 375 төрийн албан хаагчдад сурталчилсан.

Эрх зүйн албан ба албан бус сургалтыг 8, сурталчилгааг 3, хэлэлцүүлэг 2 удаа тус тус зохион байгуулж 944 гаруй иргэнийг хамруулж, зөвлөгөө, лавлагаа, баримт бичиг боловсруулах чиглэлээр 23 иргэнд эрх зүйн туслалцаа үйлчилгээг үзүүлжээ.

Сайхан-Овоо сум Төрийн албаны хууль тогтоомжийн гарын авлага боловсруулан албан хаагчиддаа тараан мөрдөн ажиллаж байна.

Боловсрол, соёл, урлагийн газар нь боловсрол, соёл, урлагийн холбогдолтой УИХ, МУ-ын Засгийн газрын 4 тогтоол, ЗГ-ын хуралдааны 3 тэмдэглэл, аймгийн ИТХТ-ийн 2 тогтоол, Засаг даргаас баталсан 6 захирамж нийт 14 эрх зүйн актыг сумдын сургууль, цэцэрлэг, соёл урлагийн 58 байгууллагын 622 удирдлага, албан хаагчид, 250 гаруй иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 10 дугаар хурлаар сум, агентлагийн дарга нарын 2018 оны үр дүнгийн гэрээний эхний хагас жилийн үнэлгээний дүнг хэлэлцээд, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэхтэй холбогдолтой зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийг сар, улирлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж, үр дүнд хүргэж ажиллах үүрэг чиглэл өгсөн. Зөвлөмжийг www.Dundgovi.gov.mn цахим хуудсны “Ил тод байдал” талбарын “Хүний нөөц”-ийн “Үр дүнгийн гэрээ” хэсэгт байршуулан сурталчилж байна.

/Зөвлөмжтэй <http://www.dundgovi.gov.mn/mn/index.php?pid=656> линкээр орж танилцаж болно./

Тав. Орон нутаг салбарын хэмжээнд хууль, журам заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

Хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэнд 2018 оны 1 сард хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг ХШҮДАХ-тэй хамтран тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж, зөвлөгөө чиглэл өгч, түүнийг хэрэгжүүлэх ажлыг сум, агентлагуудад хийж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний үеэр сумын төрийн байгууллагууд болон Засаг даргын эрхлэх хүрээний агентлагуудын Хүний нөөцийн ил тод байдал, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар 2017 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийсэн ажлыг Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хавсралтын дагуу дүгнэж, зөвлөгөө чиглэл өгч ажилласан.

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар 2017 онд дэвшүүлсэн зорилтын биелэлт 5 агентлаг 100%, 8 сум, 9 агентлаг 90-100%, 7 сум, 3 агентлаг 80-90%, 3 агентлаг 70-80%, 1 агентлаг 60-70%-тай дүгнэгдэж, дундаж хувь 90,38 байна.

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар Засаг даргын Тамгын газрын 2017 онд дэвшүүлсэн зорилтын 91,67-тай байлаа.

Хяналт шинжилгээ үнэлгээний дүнг www.Dundgovi.gov.mn цахим хуудсны “Ил тод байдал” талбарын “Хүний нөөц”-ийн “удирдлагын ил тод байдал” хэсэгт байршуулан сурталчилж байна.

Хяналт шалгалтын явцад сумд байгууллагуудын стратеги төлөвлөгөөгөө шинэчилсэн, Төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөртэй түүнийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөө гарган ажилласнаар төрийн албаны үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан, сум байгууллагуудад албан хаагчдыг амьдрах орон сууцаар хангасан, аймгийн туршлагын санд багш нарын хичээл, болон багш нарын сурган хүмүүжүүлэх илтгэлийг оруулж бүртгүүлсэн, Төрийн албан хаагчийг төрийн албан хаагчдаас санал авч шалгаруулсан, албан хаагчдаа дотооддоо болон гадаад улсад туршлага судлуулсан, иргэдээс төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, ёс зүйн талаар санал асуулга авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн, байгууллага бүр төрийн албан хаагчдын судалгааг жил бүр шинэчилж хэвшсэн, Төрийн албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон ёс зүйн харилцааны ур чадварыг хөгжүүлэх замаар иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх чиглэлийн ярилцлага хэлэлцүүлэг зохион байгуулсан, Төрийн захиргааны албан хаагчдын ажлыг улирал бүр тусгай шалгуур үзүүлэлтээр дүгнэж, үнэлгээний дүнг жилийн эцсийн ажлын үзүүлэлтэд оруулан дүгнэдэг зэрэг ажлын сайн туршлагууд байлаа.

Мөн үүний зэрэгцээ ажлын зөрчил дутагдал байгааг арилган сайжруулах чиглэлийг холбогдох байгууллагуудад зөвлөмжөөр өгч, сум байгууллагуудад гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж хэвшсэн.

Зургаа. Төрийн байгууллагын албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн. Төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн

Төрийн бүх шатны байгууллагад төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, төрийн албаны шинэчилсэн хууль тогтоомж, стандартуудыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын мэргэшлийг тасралтгүй дээшлүүлэн чадваржуулж төрийн албаны залгамж чанарыг дархлаажуулах, төрийн үйлчилгээний нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллахад гол анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдах сургалтын графикийг



улирал тутам гарган хэрэгжүүлж 2012-2017 онд давхардсан тоогоор 587 удаагийн сургалтанд 21488 төрийн албан хаагчид хамрагдсан байна. Үүнийг он оноор харуулбал:

Төрийн албан хаагчдын 2018 оны нэгдсэн сургалтын график болон улирал бүр орон нутагт зохион байгуулах сургалтын графикийг гарган хэрэгжүүлж байна. Төрийн албан хаагчдын 2018 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 86 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 4186 төрийн албан хаагч, улс бүсийн хэмжээний 143 удаагийн сургалтад 296, нийт 229 удаагийн сургалтад 4482 төрийн албан хаагч, гадаад улс оронд зохион байгуулагдсан сургалт арга хэмжээнд 28 албан хаагч тус тус хамрагдсан байна.

Удирдлагын академийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээний чанарыг сайруулах арга зам” сэдэвт сургалтыг орон нутагт зохион байгуулж, зайны сургалтанд 9, богино хугацааны сургалтад нийт 50 төрийн албан хаагчид хамрагдсан.



Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөлт, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор Канад улсын Мерит төслийг аймагтаа хэрэгжүүлж, “Үндсэн чиглэлийн зорилтыг тодорхойлох нь” Дорнод аймгийн туршлага солилцох сургалт, “Төрийн албаны харилцаа, хандлага”, “Ухаалаг зорилтуудыг

тодорхойлох нь”, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” зэрэг 4 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 150 албан хаагч хамрагдлаа.

Төрийн байгууллагуудад албан хаагчдынхаа сургалтын хэрэгцээний судалгааг авч, ажлын байран дахь сургалтын тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан байна.

Энэ ажлын хүрээнд төрийн байгууллагуудад ажлын байран дахь 145 удаагийн сургалтыг 2175 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан байна.

Боловсрол, соёл, урлагийн газраас “Байгууллагын албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг шинэчлэн баталж, ДЗОУБ-тай хамтран “Миний гэр бүлийн баяр хөөр” сэдэвт сургалт, Татварын хэлтэс Хүний эрхийн үндэсний комисс болон Дэлхийн зөн ОУ-ын байгууллагатай хамтран хүний эрх, эрх чөлөө, харилцааны соёл зэрэг сэдвүүдээр сургалт, Баянжаргалан, Гурвансайхан сум Хувь хүний хөгжлийн институттэй хамтран “Хөгжлийн эзэд” сургалт, Адаацаг сум аймгийн ҮЭ-тэй хамтран ХАБЭА сэдэвт, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран “Хүн байрын учир” сургалт, Хулд сум Гэр бүл судлаач лектор авчирч ажлын байран дахь сургалтыг үр дүнтэй бүтээлч хэлбэрээр зохион байгуулсан байна. Сум, агентлагийн дарга нарын эхний хагас жилийн гэрээний биелэлтийг дүгнэж, төрийн байгууллагуудын албан хаагчдын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хавсралтын дагуу улирал тутам дүгнэж, удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлж ажиллах талаар сумын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлж ажилласан



Долоо. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлаар зохион байгуулсан ажил үр дүн

Төрийн байгууллагуудад Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөртэй ажиллах талаар 2018 оны үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж, эхний хагас жилийн биелэлтийг тооцон Засаг даргын Зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн зөвлөмж чиглэл өгч эрчимжүүлж ажилласан .

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь заалтын дагуу нийт сум, хэлтэс, агентлагууд байгууллагынхаа төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөртэй, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөтэй тухайн жилдээ 3-6 зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж ажилласан нь зохих үр дүнгээ өгч байна.

Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Сайнцагаан сумын байгууллага бүр албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, сумын ЗДТГазрын албан хаагчдад дэмжлэг тусламж /хоолны хөнгөлөлт, төрийн үйлчилгээний ажилчдын ур чадвар, жижүүрийн илүү цаг, бусад тусламж /-д 8.846.473 төгрөг, Ерөнхий боловсролын сургуулиуд: албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 20.552.000, цэцэрлэгүүд: 29.103.000 төгрөг зарцуулсан байна.

Хулд сумын ЗДТГ албан хаагчдынхаа ажиллах орчинг сайруулах зорилгоор 30,0 сая төгрөгийн дотоод тохижилт хийх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

Дэлгэрцогт сум 6, Говь-Угтаал сум 9 төрийн албан хаагчийг халаалттай байранд оруулж, Говь-Угтаал сум 12 төрийн албан хаагчийн байрыг нэгдсэн халаалтад холбож нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн

Говь-Угтаал суманд төрийн албан хаагчийн 12 айлын орон сууц барих ажил 90% гүйцэтгэлтэй байна. Гэр нь галд өртөж орон гэргүй болсон 1 төрийн албан хаагчид байгууллага сумын иргэдийн хандиваар шинэ гэр барьж өгч, нийгмийн халамжийн шугамаар 1200.000 төгрөгний санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Сайхан-Овоо сумын ЗДТГын халаалтын шугамд ОНХС-гийн 22,0 сая төгрөгийн хөрөнгөөр тохижилт хийж байна.

Сум, агентлагийн дарга нарын эхний хагас жилийн гэрээний биелэлтийг дүгнэж, төрийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 89 дүгээр тогтоолын хавсралтын дагуу улирал тутам дүгнэж, удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлж ажиллах талаар сумын Засаг дарга, агентлагийн дарга нарт зөвлөмж хүргүүлж ажилласан.

Бүх сумдыг интернетэд холбож, цахим орчин бүрдүүлэн, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох шуурхай байдлыг хангаж, байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрээр сурталчилах боломж бүрдсэн.

Төрийн байгууллагууд стандартын цахим хуудастай болгож, И-оффис системийг хөгжүүлж, сум байгууллага бүрийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтөлөлтийг цахим орчинд шилжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэн хэвшүүлж байна.

2018 онд аймгийн хэмжээнд ажилдаа амжилт гаргаж хамт олноо манлайлан ажилласан 24 хүнийг төрийн дээд одон медалиар, 17 хүнийг Засгийн газрын шагналаар, 3 байгууллагыг аймгийн “Тэргүүний хамт олон”-оор шалгаруулж, аймаг орны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан 2 иргэнийг “Аймгийн хүндэт иргэн”-ээр, 4 иргэнийг “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж алдаршуулан, 9 ажилтныг аймгийн “Тэргүүний ажилтан”, 35 малчныг аймгийн “Аварга малчин” цол тэмдгээр, 58 хүнийг “Хүндэт тэмдэг”-ээр, 69 иргэнийг “Жуух бичиг”-ээр тус тус шагнаж урамшуулсан.



Мөн Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа бүтээлч төрийн албан хаагчдыг шалгаруулж урамшуулах зорилгоор “Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж урамшуулах журам”-ын Эрүүл мэндийн салбарын шилдэг төрийн албан хаагч шалгаруулж, 2 их эмч, 2 сувилагчийг аймгийн “Шилдэг төрийн албан хаагч”-аар өргөмжилж, тус бүр 1,0 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан.

Найм. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэх ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Төсвийн байгууллагуудад томилгооны зөрчилгүй ажиллуулах зорилгоор захиалгыг үндэслэн 2012-2017 онд төрийн жинхэнэ албаны болон үйлчилгээний байгууллагын удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 31 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 127 ажлын байрыг нийтэд зарлаж, 174 хүн сонгон шалгаруулалтад бүртгүүлж, үүнээс 96 нь шалгалтандаа тэнцэж 65-ыг нь тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлсэн байна. Үүнийг оноор харуулбал:



Төсвийн байгууллагуудын санал, захиалгыг үндэслэн 2018 онд төрийн захиргааны 2, үйлчилгээний 7 байгууллагын дарга /эрхлэгч/-ын албан тушаалд томилогдох ажилтнуудын сонгон шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулсан.

Энэхүү 4 удаагийн сонгон шалгаруулалтаар 7 ажлын байранд 11 иргэн бүртгүүлж орсноос 4 иргэн тэнцэж, 2 иргэнийг нэр дэвшүүлсэн.

Удирдах албан тушаалд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 4 ажлын байранд Төрийн албаны зөвлөлөөс ирсэн зөвлөмжийн дагуу комисс тоилон сонгон шалгаруулж, 4 иргэнийг нь Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гарган сум, байгууллагын төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нэр дэвшүүлж, томилуулсан.

Сонгон шалгаруулалтыг УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоол, ТАЗ-ийн 2013 оны 14 болон 60 дугаар тогтоолоор батлагдсан журам, зааврын дагуу зохион


байгуулсан. Сонгон шалгаруулалтын зар, түүний дүн мэдээг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайт, аймгийн www.Dundgovi.gov.mn сайт, болон орон нутгийн Ард телевиз, аймгийн болон сумдын Засаг даргын Тамгын газрын facebook хуудас, мэдээллийн самбар, аймаг, сумдын Засаг дарга нарын шуурхай цуглаанд 2-3 удаа мэдээлэн тогтмол сурталчилж хэвшсэн.

Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын сорилын шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.

Удирдах ажилтны сонгон шалгаруулалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдийн жагсаалтыг гаргаж, ил тод сурталчилж байна.

Ес.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод байдлыг хангасан байдал, үр дүн

Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийг сонгон шалгаруулах мэргэшлийн шалгалтыг 2012 оноос хойш цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 362 ажлын байр нийтэд зарлагдаж, 965 иргэн бүртгүүлж, эдгээрээс 3366 иргэн шалгалтад тэнцэж, өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авсан 110 иргэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тухайн ажлын байрандаа нэр дэвшүүлэн томилогдсон байна. Үүнийг оноор харуулбал:



Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалгыг үндэслэн Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2018 онд 2 удаа зохиж журам, удирдамжийн дагуу ил тод, нээлттэй зохион байгуулж явуулсан.

Энэхүү 2 удаагийн мэргэшлийн шалгалтаар 40 ажлын байр зарлагдсанаас 28 ажлын байранд 81 хүн бүртгүүлж, эдгээрээс 29 хүн шалгалтандаа тэнцэж, өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авсан 14 иргэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тухайн ажлын байрандаа нэр дэвших болзол хангасан байна.



Одоогийн байдлаар Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд хамрагдсан хамгийн өндөр оноо авч 1-ээр гарсан 5 иргэнийг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлж, томилогдсон байна.

[Төрийн албаны мэргэшлийн шалгалтын мэдээллийг www.dundgovi.mn сайтын Төрийн албаны салбар зөвлөл

талбарын Ил тод байдал хэсгийн Төрийн жинхэнэ албаны нөөц хэсэгт болон бусад мэдээллийн талбараар сурталчилж байршуулсан болно/

Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг ТАЗ-ийн 2013 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан журам, зааврын дагуу зохион байгуулсан. Мэргэшлийн шалгалтын зар, түүний дүн мэдээг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайт, аймгийн www.Dundgovi.gov.mn сайт, болон орон нутгийн Ард телевиз, аймгийн болон сумдын Засаг даргын Тамгын газрын facebook хуудас, мэдээллийн самбар, аймаг, сумдын Засаг дарга нарын шуурхай цуглаанд 2-3 удаа мэдээлэн тогтмол сурталчилж хэвшсэн.

Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд 26-27 хүний багтаамж бүхий цахим шалгалт явуулах байр бэлтгэн, шалгалтын явцын бичлэг хийж, танхимын гадна талд телевизээр шалгалтын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй харуулах болон ТАЗ-өөс шууд хянах боломж нөхцөлийг бүрдүүлж, шалгалтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан.



Арав. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн

Төрийн жинхэнэ албаны нөөцийн санг анх орох иргэний нөөц, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц гэсэн 2 ангиллаар бүрдүүлсэн.

2018 оны 6 дугаар сарын 25-ны байдлаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн санд дэс түшмэлийн 54, туслах түшмэлийн 7 нийт 61 иргэн бүртгэлтэй байна. /Төрийн жинхэнэ албан нөөцийн мэдээллийг www.dundgovi.mn сайтын Төрийн албаны салбар зөвлөл талбарын Ил тод байдал хэсгийн Төрийн жинхэнэ албаны нөөц хэсэгт байршуулсан болно./

Нөөцийн сангийн баяжилтийг тогтмол хийж, нөөцийн бүртгэлд байгаа иргэдийг мэргэшлийн чиглэлээр нь ангилан, нэрсээр нь тодруулж гарган, 16 байгууллагад нөөцийн мэдээллээр үйлчилсэн байна. Нөөцийн сангийн мэдээллээ байгууллагууд цахим хуудаснаас авч байна.

Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоо, түүнийг нөхөх талаар авсан арга хэмжээний мэдээллийг орон нутгийн телевиз, Засаг даргын шуурхай цуглаан, семинар цугларалтын үеэр болон Салбар зөвлөлийн мэдээллийн самбараар нийтэд ил тод болгож, тогтмол мэдээлж хэвшсэн.

Салбар зөвлөлөөс сум, хэлтэс, агентлагуудын захиалгын дагуу нөөцийн жагсаалтад бүртгэлтэй байсан 16 иргэнийг захиалгат ажлын байранд нэр дэвшүүлж, томилуулсан.

Арван нэг. Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн санг бүрдүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөц бүрдүүлэх журам” –ын сум байгууллагад холбогдох заалтуудыг хяналтанд авч хэрэгжилтийг улирал тутам дүгнэн ажиллаж байна.

2018 онд төрийн албан хаагчийн нөөцийн жагсаалтанд 1 хүнийг шинээр бүртгэж, 2 хүнийг нөөцөөс нэр дэвшүүлж, 6 сарын байдлаар төрийн жинхэнэ албаны нөөцөд 22 хүн бүртгэлтэй байна.

/Нөөцийн мэдээллийг Dundgovi.gov.mn цахим хуудсны Төрийн албаны салбар зөвлөл /ТАСЗ/ талбарын “Ил тод байдал” хэсэгт байршуулан сурталчилж байна./

Арван хоёр. Төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээг байгуулах, дүгнэх асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах дүгнэх журмын дагуу Сумдын Засаг дарга, төрийн захиргааны байгууллагууд, төсөвт байгууллагын дарга нартай байгуулах 2018 оны үр дүнгийн гэрээг байгуулсан.

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын болон төрийн захиргааны албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинд өгсөн үнэлгээг салбар зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн, зохих дүгнэлт өгч баталгаажуулан, цаашид анхаарах асуудлаар нийт сум хэлтэс, агентлагуудын удирдлагуудад зөвлөмж, чиглэл өгөх ажил хэвшил болсон.

Төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, “Менежерийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-уудыг нийт сум, байгууллагуудад мөрдүүлэн ажиллаж, ерөнхий менежерүүдээс дээрх журам, заавруудыг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт шинжилгээ хийж, анхаарах асуудлуудаар тухай бүр нь заавар, зөвлөмж өгч арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

Аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулах гэрээг бэлтгэн, Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга, агентлагын дарга нартай 2018 онд хамтран ажиллах, үр дүнгийн гэрээ байгуулах ёслолын ажиллагааг зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Цэргийн штабын дарга, 14 сумын Засаг дарга, 20 агентлагийн дарга нийт 38 байгууллага, нэгжийн дарга гэрээнд гарын үсэг зурж, гэрээг хэрэгжүүлэх талаар сургалт семинар хийсэн.

Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад, төрийн байгууллагуудын удирдлагуудтай байгуулсан 2017 оны үр дүнгийн гэрээ, 2018 оны гэрээний эхний хагас жилийн хэрэгжилтийг дүгнэж, цаашид ажил эрчимжүүлэх үүрэг даалгавар өгч үр дүнг тооцон ажиллаж байна.

Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 21 агентлагийн 2017 оны гэрээний биелэлт “А” үнэлгээтэй -19, “В” үнэлгээтэй 2, үнэлгээний дундаж хувь 93,34, 2018 оны эхний хагас жилийн биелэлт “А”- 11, “В”- 5, “С”-5, А,В-ийн эзлэх хувь 76.19%, дундаж хувь 87,32%-тай байна.

Төрийн байгууллагуудад үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг мэргэжилтнүүдийг байлцуулан нэг бүрчлэн хамгаалуулж үнэн шударга үнэлж, дүгнэх, хэрэгжихгүй, удаашралтай байгаа заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, цаашид ажил сайжруулах зөвлөмж, чиглэл өгч ажилласан. Хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг улирал бүр дүгнэж, гэрээгээр хангалттай сайн үнэлэгдсэн ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгож байна.

Эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийг улирал бүр ажлыг нь Засгийн газрын 150 дугаар тогтоолын дагуу дүгнэж урамшууллыг 30-45 хувиар олгосон байна.

Мөн төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээний үнэлгээний мөрөөр журамд заасны дагуу шатлал ахиулах, шинээр зэрэг дэв олгох буюу өмнөх зэрэг дэвийг нь

ахиулах, мөнгөн урамшуулал олгох зэрэг холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.

ЗДТГ-ын албан хаагчдын үр дүнгийн гэрээний үнэлгээний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж, 9 албан хаагчдад зэрэг дэв ахиулах ба шинээр олгож, 3 албан хаагчийн шатлалыг ахиулж, 2 албан хаагчид удаан жилийн нэмэгдэл шинээр, 4 албан хаагчид үр чадварын нэмэгдлийг шинэчлэн олгож, нийт 29 албан хаагч зэрэг дэв, цолны нэмэгдэл болон удаан жилийн нэмэгдэл, 6 албан хаагчид үр чадварын нэмэгдэл, 7 албан хаагчдад мэргэшлийн зэргийн, 2 албан хаагчид онцгой нөхцөлийн нэмэгдэл олгож байна.

Арван гурав. Ёс зүйн хороог арга зүйн удирдлагаар хангаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн

Төрийн албан хаагчдын дунд ёс зүйн, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах талаар сум байгууллагын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж байгууллагууд тусгай төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд төрийн захиргааны байгууллагуудад 23 ёс зүйн хороо ажиллаж, төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, тэднийг соён гэгээрүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан.

Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагуудад ёс зүйн хороогоо шинэчлэн байгуулах, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, төрийн албан хаагчдын ашиг сонирхолыг зохицуулах, хувь хүний хөгжил зэрэг чиглэлээр 775 албан хаагчийг хамруулан сургалт зохион байгуулсан.

Төрийн байгууллагуудад төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл, ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, 7 сум, 15 агенлаг төрийн албан хаагчидтайгаа ёс зүйн гэрээ байгуулсан, бусад байгууллагуудад байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, албан хаагчдын хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжилтийг дүгнэн ажиллаж, 7 сум, 2 байгууллага ёс зүйн зөрчил гаргаж, ажлын сахилга хариуцлага алдсан 23 албан хаагчид сахилга хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авсан байна.

Төрийн байгууллагуудад төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах талаар байгууллагын дотоод журамдаа тусган хэрэгжүүлж байна.

Төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт ёс зүй, сахилга хариуцлагыг тооцож ажиллах талаар Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Татварын хэлтэс, Дэлгэрхангай, Адаацаг сумын төрийн байгууллагууд, хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулан нэмж тусгасан байна.

Үүний зэрэгцээ Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулах, сахилга хариуцлагыг сайжруулах журмыг боловсруулан мөрдүүлж, Нийгмийн даатгалын хэлтсээс байцаагч ажилчдын ёс зүйн зөрчлийн талоныг хэрэгжүүлсэн байна.

Сайхан-Овоо сум 2018 оныг “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах жил” болгон зарлаж, төрийн албан хаагчдад хууль эрх зүйн болон төрийн албан хаагчдын ажил хэрэгч харилцаа, хувцаслалт биеэ авч явах соёл зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 74 буюу 78,8%-ийг хамруулсан байна.

Арван дөрөв. Өргөдөл гомдол, маргаан, ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хагас бүтэн жилээр ирүүлсэн байдал:

Иргэдээс болон төрийн албан хаагчдаас салбар зөвлөлд 9 өргөдөл, гомдол ирснийг 6-г салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, бусдыг нь шууд хариу өгөх замаар шийдвэрлэсэн.

Ирсэн өргөдлийг бүтцээр нь авч үзвэл нөөцөөс нэр дэвшүүлэх буюу ажилд орохыг хүссэн 5 байгаа нь хамгийн их буюу нийт ирсэн өргөдлийн 55,6 хувийг эзэлж байна. Ажилд буцаан оруулах, удирдах ажилтны сонгон шалгаруулалтад орох, албан хаагчдын ёс зүйтэй холбоотой, ажлаас буруу халсан тус тус 1 өргөдөл ирсэн байна.

Төрийн жинхэнэ албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ыг баримталж Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өмнөх урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болгоход анхаарч, салбар зөвлөлд ажлаас чөлөөлснийг эс зөвшөөрч ирүүлсэн 1 өргөдлийг журмын дагуу маргаан хянан шийдвэрлэх комисс томилон шийвэрлэсэн.

Ёс зүйн зөрчлийн мэдээг хагас жил тутам авч нэгтгэн дүгнэж хэвшсэн. 2018 онд ёс зүйн хороонд ирсэн өргөдөл гомдол байхгүй болно.

Арван тав. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн:

Салбар зөвлөлөөс хийсэн ажлын тайланг 7 хоног тутам Засаг даргын шуурхай цуглаан болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга сурталчлан ажиллаж байна.

Дундговь аймгийн Dundgovi.gov.mn цахим хуудсанд Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах “Төрийн албаны салбар зөвлөл” талбар нээн үйл ажиллагааг нь тогтмолжуулаад байна. Уг талбарт танилцуулга, шалгалтын зар, ил тод байдал, тогтоол шийдвэр, эрх зүйн акт, холбоо барих зэрэг булан нээн үйл ажиллагаагаа тогтмол сурталчилж хэвшсэн.


2018 онд удирдах ажилтны сонгон шалгаруулалт, мэргэшлийн шалгалт, төрийн албан хаагчийн нөөцийн зар, хуралдааны тойм, шийдвэрийн хэрэгжилт, шалгалтын дүн, салбар зөвлөлийн тогтоол, төлөвлөгөө, тайлан, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн мэдээлэл зэрэг нийт 11 мэдээллийг шинээр тавьж нийтэд үйл ажиллагаагаа сурталчилсан. Мөн түүнчлэн аймгийн Ард телевизид 5 удаа, Засаг даргын шуурхай цуглаанд 7 хоног бүр буюу нийт 18 удаа үйл ажиллагааныхаа талаар мэдээлсэн байна.

Бүх сумдын төв, малчдад мэдээлэл хүргэдэг Аюулаас урьдчилан сэргийлэх цогцолборын FM радиогоор сар бүрийн 1-ны өдөр сарын хийсэн ажлын мэдээлэлээ дамжуулсан.

Төрийн албаны мэргэшлийн шалгалт, төрийн жинхэнэ албаны болон төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар мэдээллийг ТАЗ-ийн болон аймгийн вэб сайт, Засаг даргын шуурхай мэдээлэл, орон нутгийн Ард телевиз, аймаг, сумын ЗДТГ-ын мэдээллийн самбараар мэдээлж сурталчилж хэвшсэн.

Бүх шатны төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагаа, нийгмийн хүндрэл бэрхшээл, асуудлын талаарх иргэдийн санал гомдлыг хүлээн авч холбогдох төрийн байгууллагад хүргэн шийдвэрлүүлэх, хариуг иргэдэд түргэн шуурхай хүргэх цахим үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санал өргөдөл гомдлын цахим сайтад 46 санал хүсэлт, өргөдөл гомдол бүртгэгдсэн бөгөөд шийдвэрлэлт 84.78%-тай байна. Иргэдээс ирсэн санал хүсэлтийг тухай бүр цахим программд оруулж, холбогдох газруудад хуваарилан шийдвэрлүүлээ. Мөн Засгийн газрын цахим сайт 11-11 төвд ирсэн 7 асуудлыг судлан хариуг өгч шийдвэрлэлтийн хувь-100% байна.



Тус онд 7059106 утас болон цахим өргөдөл гомдлын програмд 86 санал, гомдол бүртгэгдсэнээс санал хүсэлт 28, гомдол 52, шүүмжлэл байгаагийн 76 нь буюу 88,37 хувийг хугацаанд нь шийдвэрлэж, 11,63 хувь нь хугацаа хэтэрч шийдэгдсэн нь асуудлыг шинжлэн судлах асуудалтай холбоотой байсан. Цахим програмд ирсэн өргөдөл, санал, гомдлыг 7 хоног бүр нэгтгэн аймгийн Засаг даргын “Шуурхай” цуглаанаар нийтэд танилцуулж, Able програмын олон нийт

хэсэг болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан сурталчилдаг.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу Төрийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг дээшлүүлэх сумдын иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулж иргэдийн санал бодлыг сонсох, төрийн албан хаагчдад зөвлөн туслах зорилгоор Аймгийн Засаг даргын “Иргэдээ сонсоё” төрийн үйлчилгээний нэгдсэн өдөрлөгийг 2018 оны 4 дүгээр сарын 2-6-ны өдрүүдэд Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдад аймгийн Засаг дарга, Тамгын газар, 12 агентлаг, төрийн байгууллагын төлөөлөл нийт 46 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа.



Тус сумдад аймгийн Засаг даргаас иргэдтэй уулзалт зохион байгуулж, 2017 оны үйл ажиллагааны ололт, амжилт, 2018 онд дэвшүүлсэн зорилтын талаар нийт 624 иргэдэд мэдээлэл хийж, 162 иргэдийн асуулт, санал, гомдолд хариу өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, агентлаг, төрийн байгууллагууд өөрийн чиг үүргийн хүрээнд 48 ААН байгууллага, 2452 иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж, 59 төрлийн 886 ширхэг гарын авлага, тараах материалыг төрийн албан хаагч, иргэдэд тарааж ажилласан нь иргэдийн хэрэгцээг хангасан үр дүнтэй ажил болсон.

Арван зургаа. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээ ирүүлсэн байдал

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны программ хангамж, техник хангамж, сүлжээний ашиглалт, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Аймгийн ЗДТГазар нь сумдын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудтайгаа харилцан мэдээллийн эргэх холбоог шуурхай болгох үүднээс хүний нөөц, ажил хэрэг, цаг бүртгэл, албан бичиг, хэлэлцүүлэгийн зэрэг программыг багтаасан байгууллагын удирдлагын “E-office” цогц системийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж, төрийн байгууллагууд мэдээллээ харилцан солилцож хэвшээд байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрыг түшиглэн төрийн албаны мэргэшлийн шалгалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн, төрийн албаны мэргэшлийн шалгалт болон удирдах ажилтны сонгон

шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулж хэвшээд байна. Энэ оны 6 сарын шалгалтыг Төрийн албан зөвлөлөөс цахимаар хянах боломжийг бүрдүүлэн ажилласнаар шалгуулагчдын сэтгэл ханамж дээшилсэн.

2017 оны төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг шинэчилсэн программаар хийх болсонтой холбогдуулан төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 47 хүнийг хамруулан сургалт зохион байгуулж, төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 36 байгууллага, 15 сумыг хамруулан гаргах хуваарь, заавар зөвлөмжийг хүргүүлсэн.

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн шинэчилсэн программд албан хаагчдынхаа мэдээллийг оруулан тайланг хуваарийн дагуу Төсвийн 35 байгууллага, сумдын 99, нийт 134 байгууллагын 2017 оны ТАХ-ын бүрэлдэхүүн хөдөлгөөнийг тайлан мэдээллийг шинэчилсэн программд шивж оруулан мэдээллийн баазийг ТАЗ-д хүлээлгэн өгсөн.

Одоогоор программын шинэчлэл хийгдэж дуусаагүй байгаатай холбогдуулан аймгийн тайлан мэдээгээ гаргаж авч чадаагүй байна.

Арван долоо. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар хэрэгжүүлсэн шинэлэг ажил, үр дүн

Салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд ажлын төлөвлөгөөнд гишүүдийн ажил үүргийн хуваарийг мөрдөж дүгнэж ажиллах, тэдний ажлыг үнэлэх шалгуур гаргаж, урамшуулал олгох, салбар зөвлөлийн гишүүдэд хурлын мэдээллийг цахим шуудангаар болон бичгээр хүргэж, хуралд оролцохдоо холбогдох хууль, журмууд судлах боломжийг бүрдүүлэх, төрөл бүрийн сургалтуудад хамруулах зэрэг ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Салбар зөвлөлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх үүднээс “Салбар зөвлөлийн хуралдааны дэг”, ТАСЗ-ийн 2014 оны 14, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь”-ыг 2016 оны 08 дугаар тогтоолоор, “Салбар зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох журам”-ыг 2016 оны 12 дугаар тогтоолоор тус тус баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Салбар зөвлөлийн гишүүдийн ажлыг үнэлж дүгнэх журмыг боловсруулан, салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж, 2014 онд 1940,0, 2015 онд 1720, 2016 онд 2000,0, 2017 онд 2000,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь тэдний идэвхи санаачилгыг өрнүүлсэн ажил болсон.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд www.Dundgovi.gov.mn аймгийн вэб сайтын “Төрийн албаны салбар зөвлөл” талбар нээн ажиллуулж, Төрийн албаны салбар зөвлөлийн танилцуулга, тогтоол шийдвэр, эрх зүйн акт, шалгалтын зар, ил тод байдал хэсгүүдээр салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, ажил үүргийн хуваарь, ажлын төлөвлөгөө тайлан, салбар зөвлөлийн хуралдааны шийдвэр, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар, дүн, мэргэшлийн шалгалтын зар, дүн, төрийн жинхэнэ албаны нөөцийн мэдээлэл зэрэг үйл ажиллагаагаа тогтмол сурталчилж байна. Үүний үр дүнд байгууллагууд болон төрийн албан хаагчид мэдээллийг хурдан шуурхай авч үйл ажиллагааны шуурхай байдал хангагдаж байна.

Орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа бүтээлч төрийн албан



хаагчдыг шалгаруулж урамшуулах зорилгоор “Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж урамшуулах журам”-ыг Аймгийн Засаг даргын 2017 оны А/407 захирамжаар баталлаа. Цаашид жилд аймгийн хэмжээнд 21 хүртэл шилдэг төрийн албан хаагчдыг шалгаруулж, 1.0 сая төгрөгийн урамшууллыг олгохоор боллоо.

2017 онд Шилдэг 10 багш, 2018 оны эхний хагас жилд 4 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг

шалгаруулан, тус бүр 1,0 сая төгрөгийн урамшуулал олгосон.

Төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого, төрийн албаны стандартын хэрэгжилтийн тайлан сонсголыг Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн зөвлөмж хүргүүлж ажилласнаар байгууллагуудад хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх ажлын үр дүн сайжирсан байна.

Сүүлийн 2 жилд Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумын ЗДТГ, Хүнс хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төрийн албаны стандартын хэрэгжилтийн тайлан сонсголыг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэж, зөвлөмж хүргүүлэн ажилласнаар төрийн байгууллагуудад стандартын хэрэгжүүлэх талаар бүтээлч ажлуудыг санаачлан хийдэг болсон.

Арван найм. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийтийн /иргэдийн/ үнэлгээ

Тайлангийн хугацаанд Сум, байгууллагын удирдлага, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, албан хаагчид нийт 16 хүнийг хүлээн авч уулзан, тэдний санал бодлыг сонсох, тавьсан асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүллээ.

Төрийн албанд анх орох иргэдийн нөөцийн мэдээллээр 18 байгууллагад, төрийн албаны мэргэжлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалттай холбогдолтой хууль тогтоомжийн талаар 80 гаруй хүнд сургалт зөвлөгөө өгсөн.

Арван ес. Салбар зөвлөлийн хагас, бүтэн жилийн тайлан ирүүлсэн байдал:

Тус салбар зөвлөлийн 2017 оны бүтэн жилийн тайлан 2018 оны хагас жилийн тайланг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн ажил дүгнэх үзүүлэлт”-ийн дагуу гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.

Хорь. Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг, даалгаврын биелэлт:

2018 онд салбар зөвлөлд Төрийн албаны зөвлөлөөс 4, бусад байгууллага, иргэдээс 115 нийт 119 албан бичиг тоот, 9 өргөдөл гомдол, санал хүсэлт ирж, салбар зөвлөлөөс Төрийн албаны зөвлөлд 17, бусад байгууллага, иргэдэд 79 нийт 96 албан тоот бичиг гадагш явуулсны дотор Төрийн албаны зөвлөлөөс шаардсан болон цаг үеийн графикт 3 тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн болно.

Хорин нэг. “Хариуцлагын жил”-д зохион байгуулсан үйл ажиллагаа, үр дүн

Монгол улсын Засгийн газрын 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан 12 зорилт, 44 арга хэмжээ бүхий “Хариуцлагын жилд Дундговь аймагт хийх ажлын төлөвлөгөө” гарган, аймаг, сум, байгууллагын түвшинд хэрэгжүүлэх ажлын зохион байгуулан, биелэлтийг эхний хагас жилийн байдлаар дүгнэхэд 100%-24, 70%-14, 40%-6 буюу хэрэгжилтийн хувь 82,27 байна



“Төрийн албаны сахилга хариуцлага” аймгийн Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг 340 удирдах ажилтан төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулж, аймгийн хэмжээнд тусгамдаад байгаа асуудлыг хэлэлцэн, зөвлөмж гарган хэрэгжүүлж байна.

Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн эхний хагас жилийн хэрэгжилтийн байдалд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 16 хэлтэс, агентлагуудад Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан журмын хавсралтын дагуу мэдээллийг хэрхэн байршуулж байгаа эсэхэд явцын хяналт шинжилгээ хийж, цаашид журмыг хэрэгжүүлж ажиллах, журмын хавсралтаар батлагдсан ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг бүрэн байршуулах ажлыг эрчимжүүлэх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Сумдын Засаг дарга болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нараас батлан гаргасан 775 эрх зүйн актыг хууль зүйн үндэслэлийг хянаж, гарсан зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж хүргүүлсэн. 2018 онд Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон захиргааны хэм хэмжээний эрх зүйн актын шинж агуулсан аймгийн Засаг даргын баталсан 2 шийдвэр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан 1 шийдвэрийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж холбогдох дүгнэлт, зөвлөмж авч хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 16 газар хэлтэс, агентлагийн дарга нар болон төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдалд дотоод хяналт хийхэд 246 төрийн албан хаагч цагаа бүртгүүлснээс ЭМГ-ын дарга цагийн бүртгэлд нэр байхгүй цагаа бүртгүүлдэггүй, ХХААГ-ын ажилчид хурууны хээгээр цагаа бүртгүүлдэг боловч 3,4,5 сарын цагийн бүртгэлийг харах боломжгүй дутагдал байсан бол ХХҮГазар гадуур ажилтай явсан бүртгэлийг өдөр бүр хөтөлдөг, БОАЖГазар, УЦУОШАлба зэрэг байгууллага ажлын цаг ашиглалтын журамтай, Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч нар хуваарийн дагуу өдрийн цайны цагаар ажиллаж иргэдэд төрийн үйлчилгээг хүргэдэг сайн талууд байна. ХХААГ, БТСГ-ын ажилчдын ажлын цагийн бүртгэлийг сайжруулах шаардлагатай байсан. Цаашид анхаарах асуудлыг дор бүрд нь хэлж зөвлөснөөр ажлын цаг ашиглалт төрийн албан хаагчдын сахилга хариуцлага дээшилж байна.